

Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт
гаргуулахад бүрдүүлэх материал

Эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 108 дугаар тогтоолоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд” эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна.

Эрүүл ахуйн дүгнэлт гаргуулахдаа барилгын эх загвар болон иж бүрэн ажлын зургийн нүүр хуудсанд зураг боловсруулсан байгууллагын тусгай зөвшөөрлийн шифр, хуудас бүрт зохиогчид гарын үсгээ зурж баталгаажуулсан зургийг дараах бичиг баримтын хамт хүлээн авч, эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийнэ.

Үүнд:

1. Ерөнхий архитекторын баталсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
2. Барилга байгууламжийн газар олголтод хяналт тавьсан улсын байцаагчийн дүгнэлт
3. Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл
4. Архитектур төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар
5. Унд, ахуйн ус хангамж, бохир ус зайлуулалт, цахилгаан, дулааны техникийн нөхцөл
6. Инженер геологийн судалгааны дүгнэлт
7. Эрүүл мэндийн байгууллага бол хэрэгцээний тодорхойлолт
8. Барилга байгууламжийн эх загвар зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж байгаа тохиолдолд дээрх бичиг баримтын хамт эх загвар зураг
9. Иж бүрэн ажлын зураг төсөлд хяналт хийж байгаа тохиолдолд дээрх бичиг баримт, эх загвар зурагт эрүүл ахуйн хяналт хийсэн улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт, иж бүрэн ажлын зураг

Эрх бүхий албан тушаалтан эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зургийн холбогдох хэсгийг, холбогдох бичиг баримтын хамт хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянаж, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргаж, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна. Ажлын цар хүрээ, хэмжээнээс хамаарч дээрх хугацааг нэг удаа сунгаж болно.

Энэхүү зааварт заасан бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд хүсэлтийн хүлээж авахгүй болохыг анхаарна уу!